



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Нийтийг хамарсан ажлын хөлс
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг болон 23 дугаар зүйлийн 23.1.6 дахь хэсэг, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 03 дугаар сарын А/28 тоот тушаалын 06 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГазрын нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайг сайжруулж, хог хаягдалгүй байлгах нийтийг хамарсан ажлыг хийж гүйцэтгэсэн иргэдийн ажлын хөлсийг тооцож, олгох цалинг хавсралтаар баталсугай.

2. Нийтийг хамарсан ажилд оролцсон 100 иргэний ажлын хөлсөнд зарцуулагдах төсөв 13,333,332 /арван гурван сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин хоёр төгрөг/ төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нийтийг хамарсан ажлын зардлаас гаргаж санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Банзрагч)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ГЭРЭЛМАА



бүртгэл, ажлын тайлан, татвар төлсөн баримтыг үндэслэн санхүүжилтийг олгоно.

2.4 Ажиллагсдын хөдөлмөрийн хөлсийг “ТЦҮ” ОНӨААТҮГ-ын данс руу шилжүүлнэ.

2.5 Хөдөлмөрийн хэлтэс нь төслийн хэрэлжилтийн явц, үр дүн, санхүүгийн мэдээ тайлан авна.

2.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэгч талаас шаардах эрхтэй.

Гурав. “ТЦҮ” ОНӨААТҮГ-ын эрх, үүрэг

Гүйцэтгэгч тал нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

3.1 “ТЦҮ” ОНӨААТҮГ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна. 2, 3, 23, 28, 31-хороодын нийтийн эзэмшлийн зам талбай, гуу жалганы хур хогийг цэвэрлэх, үүсмэ хогийн цэгийг устгах зэрэг ажлыг 5 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

3.1.1. Нийтийг хамарсан ажилд нийт 100 ажилгүй иргэн хамрагдана.

3.1.2 Ажиллагчдын нийт ажлын хөлс 13 333 332 /арван гурван сая гурван зуун гучи гурван мянга гурван зуун гучин хоёр/ төгрөг байна.

3.1.3 ХАОАТ-ыг 1 333 333 /нэг сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучи гурав/ төгрөгийг тус дүүргийн Татварын хэлтэст шилжүүлсэн байна.

3.1.4 2015 оны 02-р сарын 25-ны дотор урьдчилгаа 50% болох 6 666 666 /зургаан са зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаа/ төгрөгийг нэхэмжилж авна.

3.2 Ажиллах иргэдийн ажлын хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлаа бусад зардлыг хариуцан гаргана.

3.3 Иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг хангаж, зориулалты хамгаалалтын хэрэгсэл/ажлын хувцас, хэрэгсэл, малгай, бээлий, хамгаалалтын нүдни шил гэх мэт/-ээр бүрэн хангасан байна.

3.4 Ажиллагсдын ирцийн бүртгэл болон ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

3.5 Ажлын үр дүн, санхүүжилт, зарцуулалтын талаар Хөдөлмөрийн хэлтэст тогтоосо хугацаанд тайлагнаж байна.

3.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаас шаардах эрхтэй.

Дөрөв. Гэрээний хариуцлага

4.1 Гэрээний биелэлтийг Хөдөлмөрийн хэлтэс дүгнэн, харилцан тохиролцож протоко үйлдэнэ.

санхүүгийн дэмжлэгийг хүндэтгэх шалтгаангүйгээр заасан хугацаанд бүрэн шилжүүлээгүйгээс төсөл хэрэгжүүдэгчид хохирол учирсан бол хохирлыг барагдуулах арга хэмжээ авна.

4.3 “ТЦҮ” ОНӨААТҮГ нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, тайлан, мэдээгээ хуурамчаар гаргаж өгсөн нь тогтоогдвол хохирлыг нөхөн төлж, хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Тав. Гэрээг өөрчлөх, цуцлах

5.1 Гэрээг дараах тохиолдолд цуцална:

5.1.1 Гэрээнд оролцогч талуудын хүсэлтээр

5.1.2 Эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1 Гэрээний үүргийн биелэлтийн явцад гарах маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар зохицуулах, тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.


Долоо. Бусад зүйл

7.1 Энэхүү гэрээ нь хоёр хувь үйлдэгдэж талууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба талууд тус бүр нэг хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

СХД-ийн Хөдөлмөрийн

хэлтсийн мэргэжилтэн

...  ... Ц. Банзрагч

Утас: 93092263

“ТЦҮ” ОНӨААТҮГ

ерөнхий нягтлан бодогч

...  ... Д. Мөнхжаргал

Утас: 96029910